



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/286

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 274 дүгээр тогтоолын 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг, орон нутгийн хөгжлийн бодлого, засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтод тулгуурлан үйл ажиллагааны уялдааг хангасан “Эрчим хүчний хэмнэлтийн дэд хөтөлбөр” боловсруулан батлуулах түүнийг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Хэрлэнчулуун	-Аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга
Нарийн бичгийн дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Мөнхцэцэг	-Боловсрол соёл, урлагийн газрын дарга
	Д.Баярхүү	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
	Ц.Гэрэлмаа	-Эрүүл мэндийн газрын дарга
	Т.Жанчив	-Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний Улсын хяналтын байцаагч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүн
	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Сайханчулуун	-Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Орон тооны гишүүн
	С.Оюун-эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн мэргэжилтэн
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
	Х.Ганчулуун	-Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга
Г.Батгэрэл	-“Хэнтий ус” ХХК-ийн захирал	

2//.

2. “Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-аар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Г. Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н. ГАНБЯМБА